



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/189

Арвайхээр

**Үнэлгээний хороо байгуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Цэцэрлэгийн барилга, 75 ор (Өвөрхангай, Хархорин сум) ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Н.Ганболд -Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон  
өмчийн газрын дарга  
Нарийн бичгийн дарга: -Т.Эрдэнэсүрэн -Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон  
нутгийн өмчийн газрын худалдан авах  
ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн  
Гишүүд: Б.Мөнхбат -Аймгийн засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт,  
хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн  
Ц.Навчаа Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн  
хэлтсийн мэргэжилтэн  
Ц.Идэрсайхан –Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл,  
урлагийн газрын Төсвийн ахлах мэргэжилтэн  
Д.Уранцэцэг Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсөв санхүү  
хариуцсан ажилтан  
Б.Одсүрэн Мерси Кор ОУБ-ын Өвөрхангай аймаг дахь салбарын  
зохицуулагч (зөвшилцсөнөөр)

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Н.Ганболд)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Т.Эрдэнэсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100413